



МОНГОЛ УЛСЫН  
ТӨР ИЙН МЭДЭЭЛЭЛ  
14/19 /688/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ТОГТООЛ

858

МОНГОЛ УЛСЫН  
ТӨР ИЙН МЭДЭЭЛЭЛ  
ТОГТООЛ

860

Үндсэн хуулийн цэцийн  
гишүүнийг томилох тухай

Зохицуулалтын үйлчилгээний  
хөлсний хэмжээ, зардлын төсөв  
батлах тухай



## ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |     |
|------|---|-----|
| 200. | Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүгэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 858 |
|------|---|-----|

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |     |
|------|---|-----|
| 201. | Үндсэн хуулийн гэрлийн гинүүнийг томилгох тухай | 858 |
|      | Дугаар 17                                       |     |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |     |
|------|---|-----|
| 202. | Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай   | 859 |
|      | Дугаар 52   |     |
| 203. | Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, зардлын төсөв батлах тухай               | 860 |
|      | Дугаар 53   |     |
| 204. | Монгол туургатан хүүхдийн урлагийн III наадам зохион байгуулах тухай                | 863 |
|      | Дугаар 54   |     |
| 205. | Хэлэлцэр батлах тухай   | 864 |
|      | Дугаар 55   |     |
| 206. | Жагсаалт батлах тухай   | 864 |
|      | Дугаар 57   |     |
| 207. | Ой тэмдэглэх тухай  | 867 |
|      | Дугаар 59   |     |
| 208. | Журам батлах тухай  | 868 |
|      | Дугаар 62   |     |
| 209. | Тусгай зориулалтаар 2011 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай | 873 |
|      | Дугаар 65   |     |
| 210. | Хөтөлбөр батлах тухай   | 874 |
|      | Дугаар 69   |     |
| 211. | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай      | 881 |
|      | Дугаар 71   |     |

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт:

"11.1.4. багц хуулийн төсөл."

2/15 дугаар зүйлийн 15.10 дахь хэсэг:

"15.10.Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар Засгийн газраас багц хуулийн төслийг өргөн мэдүүлэх бөгөөд энэ тохиолдолд үзэл баримтлалыг тодорхойлох шаардлагагүй."

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2011 оны 05 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Наваан-пэрэнлэйн Жанцан, Даваасүрэнгийн Наранчимэг нарыг, Монгол Улсын



дээд шүүхийн санал болгосноор Жүгнээгийн Амарсанааг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2011 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 2 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

**Тогтоолын хавсралтад нэмэлт  
оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Олон улсын байгууллага, гэрээ, конвенцийн итгэмжит санд төлөх татвар, хандивын тухай" Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 60 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Татварыг нь улсын төсвөөс төлөх олон улсын байгууллагуудын жагсаалт"-д дор дурдсан нэмэлт оруулсугай.

"65. Олон улсын хөгжлийн үнэлгээний нийгэмлэг ЗГХЭГ".

2. Олон улсын хөгжлийн үнэлгээний нийгэмлэгийн гишүүний татварт 2011 онд төлөх 500.0 (таван зуун ) ам.долларыг төсвийн багцаасаа гаргахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

3. Цаашид татварт шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 2 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

### Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, зардлын төсөв батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 8.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Эрчим хүчний зохицуулах газрын эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2011 онд авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг хавсралт ёсоор, тус газрын 2011 оны зардлын төсвийг 856.250.0 (найман зуун тавин зургаан сая хоёр зуун тавин мянган) мянган төгрөгөөр тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД

Н.АЛТАНХУЯГ

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ  
ХҮЧНИЙ САЙД

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2011 оны 53 дугаар  
тогтоолын хавсралт

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЭЭС 2011 ОНД АВАХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ /сая.төг/
1	"Дулааны II цахилгаан станц" ХК	22.56
2	"Дулааны III цахилгаан станц" ХК	129.36
3	"Дулааны IV цахилгаан станц" ХК	326.09
4	"Дарханы дулааны цахилгаан станц" ХК	43.38
5	"Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ХК	33.03
6	"Дэргэд, Бүсийн орчим хүчний систем" ХК	22.63

7	"Даланзадгадын дулааны цахилгаан станц" ХК	4.58
8	"Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК	31.84
9	"Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК	64.31
10	"Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	18.96
11	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ХК	16.70
12	"Багануур, зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" ХК	18.03
13	"Улаанбаатарын дулааны сүлжээ" ХК	27.16
14	"Дарханы дулааны сүлжээ" ХК	5.57
15	"Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ТӨХК	3.80
16	"Багануурын дулааны станц" ХК	6.25
17	"Налайхын дулааны станц" ХК	2.82
18	Баянхонгор аймгийн "Баянхонгор-Эрчим хүч" орон нутгийн өмчит цахилгаан түгээх сүлжээ компани	2.13
19	Хөвсгөл аймгийн "Хөвсгөл эрчим хүч" орон нутгийн өмчит ХХК	2.18
20	Увс аймгийн "Улаангом-цахилгаан түгээх сүлжээ" ХХК	1.56
21	Ховд аймгийн "Ховд-цахилгаан түгээх сүлжээ" ХХК	1.43
22	Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар	1.31
23	"Дорнод нийтийн аж ахуй" ХХК	0.42
24	Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт үйлдвэр" ХХК	34.53
25	Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг	3.71
26	"Чин Хуа-МАК-Нарийнсухайт" ХХК	0.30



27	Улаанбаатар хотын "Эрчим сүлжээ" ХХК	1.22
28	Улаанбаатар хотын "Нолго" ХХК	0.23
29	Улаанбаатар хотын ОСНАА-н "Ар Жанар" ХХК	0.02
30	Улаанбаатар хотын ОСНАА-н "Ашид-Ундрах" ХХК	0.49
31	Улаанбаатар хотын ОСНАА-н "Батбаян бүрд" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	0.69
32	Улаанбаатар хотын ОСНАА-н "Ганга-Өргөө" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар	0.39
33	Улаанбаатар хотын ОСНАА-н "ТМ" ХХК	0.76
34	Улаанбаатар хотын ОСНАА-н "Дулаан Өргөө" ХХК	1.10
35	Улаанбаатар хотын ОСНАА-н "Ивэн-Эх" ХХК	0.51
36	Улаанбаатар хотын ОСНАА-н "Опен хаус" ХХК	0.95
37	Улаанбаатар хотын ОСНАА-н "Өнөр горхи" ХХК	0.65
38	Улаанбаатар хотын ОСНАА-н "Өнөр хотхон" ХХК	0.87
39	Улаанбаатар хотын ОСНАА-н "Санкомфорт" ХХК	0.79
40	Улаанбаатар хотын ОСНАА-н "Санни Хаус" ХХК	1.98
41	Улаанбаатар хотын ОСНАА-н "Сансар-Өргөө" ХХК	0.51
42	Улаанбаатар хотын ОСНАА-н "СИМС" ХХК	0.86
43	Улаанбаатар хотын ОСНАА-н "Толгойт-Иин" ХХК	0.51
44	Улаанбаатар хотын ОСНАА-н "Хайрхан Уул-Өргөө" ХХК	1.30
45	Улаанбаатар хотын ОСНАА-н "Хаусинг сервис" ХХК	0.81
46	Улаанбаатар хотын ОСНАА-н "Хөх-Асар" ХХК	2.55
47	Улаанбаатар хотын ОСНАА-н "Эма энд Би" ХХК	0.95



48	Улаанбаатар хотын ОСНАА-н "Эцэг-Эх хүү" ХХК	0.55
49	Улаанбаатар хотын ОСНАА-н "Ганбик" ХХК	0.09
50	Нийслэлийн Ус сувгийг удирдах газар	0.12
51	Улаанбаатар хотын Багануур дүүргийн "Багануур-Ус" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	0.34
52	Орхон аймгийн "Эрдэнэт ус, дулаан түгээх сүлжээ" орон нутгийн өмчит ХК	0.67
53	Орхон аймгийн "Эрдэнэт-Амьдрал" орон нутгийн өмчит ХХК	0.60
54	"Эрчим хүчний диспетчерийн үндэсний төв" ХХК	4.65
55	"Есөн булаг-Эрчим хүч" ХХК	1.67
56	"Тод дөргөн" ХХК	0.03
57	"Дөргөний усан цахилгаан станц" ХХК	- 1.80
58	"Алтай-Улиастай ЭХС" ТӨХК	1.16
59	"Богдын голын УЦС" ХХК	0.48
60	"Тайширын Гуулин УЦС" ХХК	0.57
61	"Тосонцэнгэлийн УЦС" ХХК	0.25
62	"Галуутай Хүнгүйн УЦС" ХХК	0.49
Дүн		856.25

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 2 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

### Монгол туургатан хүүхдийн урлагийн III наадам зохион байгуулах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний 100, Ардын хувьсгалын 90 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Монгол туургатан хүүхдийн урлагийн III наадмыг 2011 оны 7 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод даалгасугай.





2. Тус наадмыг зохион байгуулахад шаардагдах 62.555.000 (жаран хоёр сая таван зуун тавин таван мянган) төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД**

**С.БАЯРЦОГТ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 2 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### **Хэлэлцээр батлах тухай**

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

2011 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Софи хотод гарын үсэг зурсан "Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 2 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

### **Жагсаалт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"Бизнесийн орчны шинэтгэлийн жил"-ийн хүрээнд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зарим зөвшөөглийг хүчингүй болсонд тооцрохтой



холбогдуулан боловсруулсан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд Улсын Их Хурлаар батлагдаж, хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан хүчингүй болсонд тооцох аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**

**М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2011 оны 57 дугаар  
тогтоолын хавсралт

**ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ АЖ АХУЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН  
ЖАГСААЛТ**

№	Зөвшөөрлийн нэр
1	Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээллээс бусад/ хэвлэх тусгай зөвшөөрөл
2	Шүүх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд орчуулгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл
3	Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
4	Усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
5	Газрын кадастрын судалгаа хийх тусгай зөвшөөрөл
6	Газрын кадастрын зураглал хийх тусгай зөвшөөрөл
7	Нууцын зэрэглэлтэй байр зүйн зураг, тоон мэдээллийг хэвлэх тусгай зөвшөөрөл
8	Улс хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
9	Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
10	Шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
11	Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл



12	Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
13	Аймаг хооронд, орон нутаг, хотын доторхи болон хот орчмын нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл
14	Орон нутагт нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл
15	Иргэний агаарын хөлгийг бүтээх, түүнд өөрчлөлт, сайжруулалт хийх тусгай зөвшөөрөл
16	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг хувиараа эрхлэх тусгай зөвшөөрөл
17	Мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл
18	Малын өвчин үүсгэгчийг ургуулж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл
19	Ургамал хамгааллын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
20	Одон, медаль үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл
21	Мансууруулах бодис бүхий ургамал ашиглаж эм бэлдэх тусгай зөвшөөрөл
22	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд өмчилгээний гоо заслын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл
23	Улсын хэмжээний болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл
24	Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгоход дүгнэлт гаргах
25	Гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний талаархи Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын санал
26	Хөтөч-тайлбарлагчийн ангилал, зэрэглэл тогтоох тусгай зөвшөөрөл
27	Гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургуулийг байгуулах зөвшөөрөл
28	Гадаадын хөрөнгө оруулалттай цэцэрлэг байгуулах зөвшөөрөл
29	Нийгмийн даатгалын бүртгэлийн гэрчилгээ олгох



30	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл
31	Рашааныг савлах, халаалт, эрчим хүчний эх үүсвэрт ашиглах дүгнэлт
32	Дээд зэрэглэлийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэхэд дүгнэлт гаргах
33	Үрийн талбайд сортын хянан баталгаа хийх зөвшөөрөл
34	Барилга байгууламжийн газар сонгох, зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад гаргах эрүүл ахуйн дүгнэлт гаргах
35	Үйлдвэрлэлийн барилга байгууламжийг барьж байгуулах, өргөтгөх, шинэчлэх, газар олголт, ажлын зураг, төсөлд эрүүл ахуй, халдвар судлалын хяналт хийсэн тухай дүгнэлт гаргах
36	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэлд гаргах эрүүл ахуйн дүгнэлт

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

### Ой тэмдэглэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-д элссэний 50 жилийн ойг 2011 онд тэмдэглэсүгэй.
2. Монгол Улс НҮБ-д элссэний 50 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.
3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг зохион байгуулах хороонд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД

Г.ЗАНДАНШАТАР



Засгийн газрын 2011 оны 59 дүгээр  
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛС НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГАД  
ЭЛССЭНИЙ 50 ЖИЛИЙН ОЙ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

**Дарга**

-Монгол Улсын Ерөнхий сайд

**Орлогч дарга**

-Гадаад харилцааны сайд

**Гишүүд:**

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд;

-Батлан хамгаалахын сайд;

-Хууль зүй, дотоод хэргийн сайд;

-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд;

-Эрүүл мэндийн дэд сайд;

-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;

-Сангийн дэд сайд;

-Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;

-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын дэд сайд;

-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга;

-Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга;

-НҮБ-ыг дэмжих Монголын нийгэмлэгийн тэргүүн (тохиролцсоноор)

**Нарийн бичгийн дарга**

-Гадаад харилцааны яамны Олон улсын байгууллагын газрын  
захирал

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2011 оны 3 дугаар  
сарын 2-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 21.2-т заасныг үндэслэн Монгол  
Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Төрийн хэнхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон  
гүйцэтгэх журам"-ыг хавсралт ёсоор багалсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай"



Засгийн газрын 2004 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 111 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ч.ХҮРЭЛБААТАР**

Засгийн газрын 2011 оны 62 дугаар  
тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭХ  
ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг хангах зорилгоор төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Үйлчлэх хүрээ

2.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхэд энэхүү журмыг баримтална.

Гурав. Албан үүргийг түр орлон гүйцэтгэх нөхцөл

3.1. Төрийн албаны тухай хуулийн 21.1-д заасан эзгүй байгаа албан хаагчийн, мөн хуулийн 17.1-д заасан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд уг орон тоог нөхөх хүртэлх хугацаанд тухайн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлнэ.

3.2. Эзгүй байгаа албан хаагч гэдэгт дараахь тохиолдлыг тооцно:

3.2.1. ээлжийн амралттай;

3.2.2. эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар чөлөөтэй;

3.2.3. дотоод гадаад албан томилолттой;

3.2.4. гурван сар хүртэл хугацаагаар сургалтад хамрагдах;



3.2.5. удирдах дээд байгууллага, албан тушаалтны шийдвэрээр тусгай даалгавар, ажил үүрэг гүйцэтгэх;

3.2.6. жирэмсний болон амаржсаны амралттай;

3.2.7. хууль тогтоомжид заасан бусад шалтгааны улмаас түр эзгүй байх.

3.3. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан гэдэгт дараахь тохиолдлыг тооцно:

3.3.1. Төрийн албаны тухай хуулийн 23.1.1, 23.1.2-т заасан үндэслэлээр албан хаагчийг албан тушаалаас нь бууруулах, 23.2, 23.4-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөх, 23.3-т заасан үндэслэлээр түр чөлөөлөх, эсхүл албан хаагч өөр албан тушаалд сонгогдох буюу томилогдох;

3.3.2. Төрийн албаны тухай хуулийн 24.1-д заасан үндэслэлээр албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх;

3.3.3. Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйл, 26.1.3-т заасан үндэслэлээр албан хаагчийг төрийн албанаас халах;

3.3.4. төрийн жинхэнэ албан хаагч нас барсан болон бусад шалтгаанаар тухайн албан тушаалын сул орон тоо гарсан байх.

#### Дөрөв. Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх ажиллагаа

4.1. Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан гаргана. Шийдвэрт түр орлон гүйцэтгэх хугацааг заана.

4.2. Энэхүү журмын 3.2-т заасан эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ:

4.2.1. байгууллагын дарг, эзгүй байх хугацаанд албан үүргийг нь түүний дэд дарга, орлогч түр орлон гүйцэтгэх бөгөөд энэ тохиолдолд тусгайлан шийдвэр гаргахгүй байж болно. Дэд дарга, орлогчгүй, эсхүл тэр орлох боломжгүй бол чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар түр орлон гүйцэтгүүлнэ. Энэ тохиолдолд эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргана;

4.2.2. энэхүү журмын 4.2.1-д зааснаас бусад эзгүй байгаа удирдах, гүйцэтгэх албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлнэ;

4.2.3. албан тушаалтны албан үүргийг ажлын 15 өдрөөс дээш хугацаагаар түр орлон гүйцэтгүүлэх бол шийдвэр гаргана. Ажлын 15 өдөр хүртэлх хугацаанд шаардлагатай гэж үзвэл шийдвэр гаргаж болно.

4.3. Энэхүү журмын 3.3-т заасан төрийн жонхонго албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан хаагчийн албан үүргийг дараахь журмаар түр орлон гүйцэтгүүлнэ:

4.3.1. дэд дарга, орлогчтой байгууллагын даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан үүргийг нь дэд дарга, орлогчоор, тэд орлох боломжгүй бол чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар;

4.3.2. дэд дарга, орлогчгүй байгууллагын даргын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн даргаар;

4.3.3. байгууллагын даргаас бусад удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар тус тус орлон гүйцэтгүүлнэ.

4.4. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь түр орлон гүйцэтгэх хугацаандаа эзгүй байгаа албан хаагч болон сул орон тоо гарсан албан тушаалын эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

4.5. Эрх бүхий албан тушаалтан төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай шийдвэрт орлон гүйцэтгэх албан хаагчийн хэрэгжүүлэх эрх хэмжээг тусгайлан зааж болно.

4.6. Эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарсны дараа албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагчид тухайн ажилтны ажлыг нь хүлээлгэн өгч, шийдвэрт заасан хугацаа дууссаны дараа эргүүлэн хүлээн авна.

4.7. Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагчийг үндсэн





албан тушаалаас нь чөлөөлөгчгүйгээр албан үүргийнх нь зэрэгцээ түр орлох албан тушаалыг гүйцэтгүүлнэ.

4.8. Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай, түүнчлэн эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 сараас 1 жил хүртэл хугацаагаар эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон тохиолдолд албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай албан хаагчаар, эсхүл төрийн албанд анх орох иргэний нөөцөд бүртгэгдсэн иргэдээс сонгон авч хугацаа заан түр орлон гүйцэтгүүлнэ.

4.9. Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа албан тушаалтны албан үүргийг энэ журмын 4.8-д заасны дагуу нөхөх боломжгүй бол тухайн ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан иргэнийг Төрийн албаны тухай хуулийн 11.6-д заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 21, 23, 24 дүгээр зүйлийг баримтлан хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж болно.

#### Тав. Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсний цалин, урамшуулал

5.1. Энэхүү журмын 3.2-т заасан эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн албан хаагчид цалингийн зөрүүг тусгайлан олгохгүй бөгөөд тухайн ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ харгалзан үзэж, хууль тогтоомжид заасны дагуу урамшуулал олгож болно.

5.2. Харин энэхүү журмын 3.2.6-д заасан жирэмсний болон амаржсаны амралттай үед төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөөс томилогдсон, эсхүл хөдөлмөрийн гэрээгээр албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа иргэнд тухайн албан тушаалын цалинг олгоно.

5.3. Энэхүү журмын 3.3-т заасан сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар бодож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 5.1-д заасныг баримтална.

5.4. Эзгүй байгаа албан хаагчийн болон сул орон тоо гарсан албан тушаалын албан үүргийг энэ журамд зааснаас бусад этгээдээр түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 3 дугаар  
сарын 2-ний өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

### Тусгай зориулалтаар 2011 онд агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг тогтоох тухай

Ан агнуурын тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2011 онд тусгай зориулалтаар угалз 50, тэх 120, халиун буга 5, цагаан зээр 150, саврал чоно 40, бор гөрөөс 40, зэрлэг гахай 20, ой, хээрийн агнуурын шувуу 400 хүртэл толгойг агнуулахаар, судалгаа шинжилгээний зориулалтаар хүрэн баавгай 2, цоохор ирвэс 4 хүртэл толгойг агнуулахаар, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор хулан адуу 2 толгойг барихаар тус тус тогтоосугай.

2. Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Гадаадын иргэнд тусгай төлбөртэйгээр агнуулах агнуурын амьтны олзворын жишиг үнэ, төлбөр, хураамжийн хэмжээ"-ний жагсаалтын 2, 5, 18, 20, 21, 23 дахь заалтыг дор дурдсанаар өөрчилж, 22 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

	Ан амьтны нэр	Олзворын жишиг үнэ	Төлбөр	Хураамж
<b>Нэг.Хөхтөн</b>				
2.	Тэх а/ алтайн б/ говийн	2500,0	1500,0	500,0
		2200,0	1320,0	440,0
5.	Цагаан зээр	200,0	130,0	50,0
<b>Хоёр.Шувуу</b>				
18.	Ой, хээрийн бусад агнуурын шувуу	15,0	8,0	4,0
20.	Нугас	15,0	8,0	4,0
<b>Гурав.Загас</b>				
21.	Тул: бариад усанд нь эргүүлж тавих	100,0	70,0	20,0
23.	Бусад агнуурын загас	20,0	10,0	5,0

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 3 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгаж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй:

а/ "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

б/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах;

в/ хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны төсөвт жил бүр тусган санхүүжүүлэх;

г/ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээг хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, гадаад оронтой тогтоосон хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт хамруулах ажлыг зохион байгуулах.

3. "Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл байгуулан ажиллуулахыг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА****Ч.ХҮРЭЛБААТАР****САНГИЙН САЙД****С.БАЯРЦОГТ**

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн ойлголт бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо юм.

Улс орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад үндэсний компаниудын хөгжил чухал үүрэгтэй байдаг тул хөгжингүй орнуудын санаачилга, туршлагад тулгуурлан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас (ЭЗХАХБ) Компанийн засаглалын зарчмуудыг 1999 онд баталсан.

"Компанийн засаглалын кодекс" буюу компанийн удирдлага, зохион байгуулалтын зарчмуудыг компанийн сайн засаглалын практикийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хувийн хэвшил, Засгийн газрын байгууллагуудын түншлэлийг дэмжин хөгжүүлж, бэхжүүлэх тухай стратегийн зорилтыг дэвшүүлсэн.

Эдийн засгийн өнөөгийн нөхцөлд Засгийн газрын байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны чухал чиглэлийн нэг нь компанийн засаглалыг төлөвшүүлэн хөгжүүлэх явдал юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцааг зохицуулах хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хууль батлагдсанаар манай улсад компанийн бүтэц, зохион байгуулалтад тулгуурласан бизнесийн үйл ажиллагаа ихээхэн өргөжиж байгаа боловч хуримтлуулсан туршлага хомс, оролцогч талуудын чадавхи харилцан адилгүй, эрх зүйн болон компанийн өөрийн зохицуулалт хангалтгүй байгаагаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага сул, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох нь цөөнгүй байна.

Компанийн тухай хуулиар компани нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг, оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байгаагаас олон нийтийн өмч хөрөнгөөс бүтсэн, нээлттэй, тайлан тооцоотой, ил тод үйл ажиллагаа явуулах эрх үүрэг бүхий нээлттэй хувьцаат компани 348, хязгаарлагдмал хариуцлагатай компани нь 56700 байна.



Компанийн засаглалын кодексын асуудал Монгол Улсад 2000 оноос яригдаж эхэлсэн бөгөөд Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас Монгол Улсад 2003 онд хэрэгжүүлсэн "Компанийн засаглалын эрх зүйн орчин, практикийг сайжруулах төсөл"-ийн тайланд Компанийн засаглалын кодексыг цаг алдалгүй боловсруулж хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Энэ үеэс эхлэн төрийн болон хувийн өмчийн эрх тэгш, тэнцэртэй хөгжл, хувийн хэвшлийн аж ахуйн үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалт, удирдлага, хяналтын олон талт харилцаа, тайлан мэдээллийн системд оршиж байгаа дутагдлуудыг засахад компанийн засаглал ихээхэн чухал үүрэгтэй гэж үзэх болсон. Санхүүгийн зохицуулах хорооноос "Монголын компанийн засаглалын кодекс"-ыг 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлан гаргаж, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа болон шинээр байгуулагдах хувьцаат компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсөн нь төрийн байгууллагын зүгээс компанийн засаглалын талаархи мэдлэг мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлагыг тавих суурь болсон хэдий ч түүний хэрэгжилт төдийлэн хангалттай бус байгаа юм.

Компанийн засаглалын асуудлыг нийт компаниудын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны үндсэн зарчмуудад тулгуурлан хөгжүүлж, нээлттэй хувьцаат компани болон банк, төрийн өмчит компанийн онцлогт тохирсон нэмэлт шаардлага, шалгуурыг бий болгон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүний тулд бизнес эрхлэгч хувь хүнийг бизнесийн шударга ёс зүйтэй болгох, хуулийн этгээдийг олон улсад түгээмэл хэшил болсон Компанийн засаглалын үндсэн зарчим, кодексыг үйл ажиллагаандаа баримталдаг болгох зорилтыг зэрэгцүүлэн тавьж хөгжүүлэх нь компанийн сайн засаглалыг хөгжүүлэх суурь үзэл баримтлал болно.

Хөрөнгө оруулагч, ажил олгогч, компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлагыг тодортож, хувьцаа эзэмшигчид, ажиллагчид болон бусад оролцогч талуудын эрхийг хангах, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэх, компанийн засаглалын удирдлага, зохицуулалт, эрх зүй, мэдээллийн зохих орчин бүрдүүрж өгөхөд төрийн дэмжлэг, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Бизнесийн таатай орчныг бүрдүүлэхэд компанийн засаглалын зарчмууд, кодексыг хэрэгжүүлэх, төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг, тусалцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгааг харгалзан, Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-ийг боловсруулав.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго

### 2.1. Хөтөлбөрийн зорилго нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн

компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх зарчим, ёс зүй, хэв шинжид тулгуурласан, аж ахуйн үйл ажиллагаа удирдан зохион байгуулах нийтлэг арга барил бүхий үндэсний компани, бизнес эрхлэгчдийг бий болгоход оршино.

### Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

3.1. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтуудыг тавьж байна:

Зорилт 1. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх.

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

-Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх чиглэлээр Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;

-Хязгаарлагдмал хариуцлагатай компани, банк, санхүүгийн байгууллага мөрдөх онцлог заалтыг Компанийн засаглалын кодекст нэмж тусгах;

-Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулагчидтай байгуулах томоохон төсөл, хөтөлбөрийн гэрээнд компанийн засаглалыг хэрэгжүүлэх талаар зүйл, заалт тусгаж байх.

Зорилт 2. Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага манлайлах.

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

-Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гарган хэрэгжүүлэх;

-Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалын түвшинг тогтоож олон нийтэд мэдээлэх;

-Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, хариуцлагын байдалд үнэлгээ хийж ангилал тогтоох;

-Төрийн өмчит хувьцаат компани, үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын хариуцлага болон урамшууллыг компанийн засаглалын түвшинтэй уялдуулах.

Зорилт 3. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс



зүйг хэрэгжүүлэх компани, аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сайжруулах.

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг томилох үйл ажиллагааг Компанийн засаглалын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх;

- Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат компанийн засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах механизмыг бий болгох;

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг илүү боловсронгуй, хариуцлагатай болгох өөрчлөлт хийж, үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх;

- Компанийн засаглалын түвшний үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох.

Зорилт 4. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх.

Энэ зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоод, хувьцаа эзэмшигчийн төлөөллийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар тэдгээрийн чадавхийг бэхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх;

- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн төлөөллийн байгууллагад зориулсан сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага бэлтгэн хэвлүүлэх, түгээх;

- Компанийн засаглалыг хөгжүүлэх хүрээнд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэх;

- Компанийн засаглалын асуудлаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, туршлага судлах, түүнийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах.

#### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж Санхүүгийн зохицуулах хорооны дэргэд байгуулан ажиллуулна.

4.2. Үндэсний зөвлөл нь орон тооны ажлын албатай байна. Ажлын өгбөний үйл ажиллагааны төсвийг хөтөлбөрийн үйл ажиллагааны зардалд тусгана.

4.3. Компанийн засаглалын кодекс хэрэгжүүлэх ажлыг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч болон санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн жагсаалтад орсон хувьцаат компаниудын хувьд Хөрөнгийн бирж, төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьд Төрийн өмчийн хороо тус тус хариуцан удирдан зохион байгуулна.

4.4. Хязгаарлагдмал хариуцлагатай компаниудын үйл ажиллагаанд бизнес эрхлэх ёс зүй, компанийн засаглалын үндсэн зарчмыг нэвтрүүлэх ажлыг Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Компанийн засаглалын хөгжлийн төв зохион байгуулан мэргэжлийн холбоодын оролцоотой хэрэгжүүлнэ.

4.5. Компанийн засаглалын хөтөлбөрийг хариуцан хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, явцын талаар Компанийн засаглалын Үндэсний зөвлөлд хагас жил тутам тайлагнаж ажиллана.

4.6. Үндэсний зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

#### Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг дараахь хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:  
-Нэгдүгээр үе шат / 2011-2012 он/;  
-Хоёрдугаар үе шат /2013-2016 он/.

5.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

- улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламж, хандив;
- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар хуримтлагдсан хөрөнгө;
- гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулан улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны төсөвт жил бүр тусгана.

#### Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд

6.1. Хөтөлбөр хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:



- хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжилд ахиц дэвшил гарна;
- компанийн засаглал, хариуцлага, хяналтын тогтолцоо сайжирна, нийгмийн өмнө хүлээх компанийн хариуцлага бий болно;
- төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжинө;
- оролцогч талуудын мэдлэг, чадавхи дээшилнэ.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж эрх зүйн зохицуулалт бий болсон байх;
- компанийн засаглалын Үндэсний зөвлөл байгуулж, үйл ажиллагаа нь тогтворжсон байх;
- компанийн засаглалын үнэлгээний индексийг Хөрөнгийн биржийн жагсаалтад орсон хувьцаат компани болон төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн холбогдох байгууллага мөрддөг болсон байх;
- хөрөнгийн биржийн жагсаалтад ороогүй хувьцаат компаниудад Компанийн засаглалын кодексыг дагаж мөрдөх бэлтгэл хангагдсан байх;
- хувийн хэвшлийн компанид хөрөнгө оруулагч, ажил олгогч, хувьцаа эзэмшигч, Компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнууд зэрэг оролцогч талуудын төлөөллийн байгууллагын чадавхи дээшилсэн байх;
- компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын зүгээс үзүүлэх дэмжлэг, туслалцаа тогтворжиж хэвшсэн байх;
- хувьцаат компанийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар заавал баталгаажуулж хэвшсэн байх;
- компанийн санхүүгийн тайлан, мэдээлэл нь ил тод болсон компанийн тоо нэмэгдсэн байх.

#### Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ хийх ажлыг Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн хороо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Компанийн засаглалын хөгжлийн төв, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын хувьцаа эзэмшигчдийн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, мэргэжлийн холбоод, тэдгээрийн орон нутаг дахь салбартай хамтран гүйцэтгэнэ.

7.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, туршлагыг нэгтгэн дүгнэх, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг хөрөнгө оруулагч нарт тайлагнах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд оршино.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2011 оны 3 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 71

Улаанбаатар  
хот**Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах,  
ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай**

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газар хоорондын хэлэлцээр, бүтээгдэхүүн хуваах гэрээ, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 100 мянган орон сууц хөтөлбөр болон улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийн хүрээнд гадаадаас 2011 онд авч ажиллуулах инженер техникийн болон мэргэжлийн ажилтанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хавсралтад заасан аж ахуйн нэгжид зохих журмын дагуу олгохыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газраас БНХАУ-ын Засгийн газар, Азийн хөгжлийн банк, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сан, "Абу Даби" хөгжлийн сантай байгуулсан гэрээнд аливаа татвар, төлбөрөөс чөлөөлөхөөр заасны дагуу "Чайна гео-инжиниринг" корпорацийн 370, "Шингли инжиниринг энд констракшн" компанийн 272, "Чайна жиансу жианда констракшн" компанийн 281, "Синохайдро" корпорацийн 10, "Хунан констракшн инжиниринг групп" корпорацийн 300, "БСИЖМН" ХХК-ийн 140 инженер техникийн болон мэргэжлийн ажилтныг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд ажлын байрны төлбөрөөс зохих журмын дагуу чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолын дагуу авч ажиллуулах гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг 2011 онд багтаан буцаан гаргах ажлыг зохион байгуулж дүнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд мэдээлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Батлан хамгаалахын сайд Л.Болд нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД****С.БАТБОЛД****НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД****Т.ГАНДИ**

УУЛ УУРХАА, ЗАМ, ЭРЧИМ ХҮЧ, БАРИЛГА, ГАЗРЫН ТОСНЫ ХАЙРУУЛЫН ЧИГЛЭЛЭЭР  
ТҮЛ АЖИЛЛАГАА ИВЭРҮҮЛЖ БАЙГАА ЗАРУМ АЖ АХУЙН НЭГЖИЙН 2011 ОНД  
ГАДААДААС АВЧ АЖИЛДУУЛАХ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН БОЛОН  
МЭРГЭЭЖЛИЙН АЖИЛТАН

№	Аж ахуйн ангидын нэр	Түл ажиллагааны чиглэл	Барих объект, гүйцэтгэн ажил	Гадаргын өмч ажиллуулалтын өртөө	Ажлын байрны төлбөрийн өртөө журмын дагуу төрөлөөгддэг ажилны 100	Төлбөр
1	"Цэцэг" төр-мөхөөрөгч нэгж	Азийн өргөлцөмт баяны өргөлцөмтэй зэвсгийн үзвэрчээр хэрэглэх байгаа Чойр Сайншанд-Завхан Тусдын чиглэлийн 432 км хатуу гучилттай зам барилгын ажил	Баян 51-ийн 131.2 км авто зам	370	370	Монгол Угс, Азийн өргөлцөмт баян хооронд 2005 оны 1 дугаар сарын 26-ны өдөр зээлийн гэрээ МОН-2007/байгуулсан
2	"Шинэ инженер" чад. констракшн" компани	Азийн өргөлцөмт баяны бүтэцтэй тусламжаар баригдан хэсэг ажилын Тэмээн нүүрч-Баян Улаан даваа чиглэлийн 110.8 км хатуу гучилттай зам барилгын ажил	Баян 107-ийн 62.2 км Баян АР 2-ийн 18.2 км туслах зам	272	272	Монгол Угс, Азийн өргөлцөмт баян хооронд 2005 оны 1 дугаар сарын 26-ны өдөр зээлийн гэрээ МОН-2007/байгуулсан
3	"Цэцэг мэдээ чиглэл констракшн" компани	Монгол Улсын Засгийн газар хоорондын зэвсгийн үзвэрчээр баригдан Хөдд ажилын Тэмээн нүүрч-Баян Улаан даваа чиглэлийн 110.8 км хатуу гучилттай зам барилгын ажил	Хөдд ажилын Аугай, Мөст сүмдэд баригдаж 7 км-ын хатуу-Баян-Улаан даваа чиглэлийн 110.8 км авто зам	281	281	Монгол Улсын Засгийн газар, Азийн өргөлцөмт баян хооронд 2008 оны 4 дугаар сарын 18-нд бүтэцтэй тусламжийн гэрээ байгуулсан
4	"Цэцэг гэгээлэг гурим констракшн" компани	Монгол Улсын Засгийн газар хоорондын зэвсгийн үзвэрчээр баригдан Хөдд ажилын Хөдд-Мандан сүм чиглэлийн 85.3 км авто зам, Баян-Өлгий ажилын Болой, Хашаарын даваа чиглэлийн 60 км хатуу гучилттай зам барилгын ажил	145.3 км авто зам	574	-	Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын хооронд төлбөр баяны хооронд байгуулсан Завхан өргөлцөмт гэрээ Сэлэнгэ мэдээ болон БНХАУ-ын хооронд төлбөр баяны хооронд зээлийн тусламжийн гэрээ байгуулсан
5	"Инжээдэр" -орсруу	Ардын эрэн ажилын өргөлцөмт Кувейтын сав "Абу Даб" өргөлцөмт баяны зэвсгийн үзвэрчээр баригдан Тэйхирын усан цэвэрлэлийн станцын барилга	Тэйхирын усан цэвэрлэлийн станцын барилгын ажилын үргэлж "тонд" төлбөрийн-гучилттай	40	10	Монгол Улсын Засгийн газар, Ардын эрэн ажилын өргөлцөмт Кувейтын савын хооронд болон Засгийн газар "Абу Даб" өргөлцөмт баяны хооронд 2002 онд гэрээ байгуулсан

6	"БСЭМБЭНГ" ХХК  БНМАУ-ын Бүтэцгүй Тусламжаар баригдах Бөтөл- жээгээс хамгаалах замын аргаар Энхийн сайнгуулгын нөхөн саргаа цэргэ-бэр тээвэр барих	Энхийн сайнгуулгын нөхөн саргаа цэргэ-бэр тээвэр бариха	140	Монгол Улс, БНМАУ-ын хооронд 1954 оны 4 дугаар сарын 29-нд хөдөө газрын үйлдвэр "Монгол Улс, БНМАУ-ын нийслэл хөршөөд, хялтын ажиллагааны тухай гэрээ"-г үндэслэн 2005 оны 7 дугаар сарын 13-ны өдөр "Бөтөл хамгаалах саргаа дахь хялтын ажиллагааны тухай" Монгол Улс, БНМАУ-ын Бөтөл хамгаалах зам хооронд хөдөө газар байгуулах
7	"Хүдэн хэвтрэн мөчлөгчүүд" ХХК  БНМАУ-ын Бүтэцгүй Тусламжаар баригдах Мэргэслэлийн хялтын өргөн газарын нэгдсэн тээвэр лаборатори	Тээвэр лаборатори-бариха	300	Монгол Улсын Засгийн газар, БНМАУ-ын Засгийн газар хооронд 2005 оны 11 дугаар сарын 28, 2006 оны 11 дугаар сарын 22, 2007 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газар, тэнгэрийн хялтын ажиллагааны хэлцүүдээр байгуулах
8	"Доншин газрын тос" ХХК	11 цонгог өргөмж, 28 цонгог гэрээгээс хамгаалах зам, 15 цонгог өргөмжтэй нэг бүрэн төвлөрөл туршигдсан, 15 цонгог эргэн хувируулах	200	
9	"Төрдөн сай мөчлөгчүүд" ХХК	Хялгууны 4 цонгог үндэслэн 4 цонгог өргөмж, 20 цонгог Туркшын цонгогт мөх	500	
10	"Петролмат" ХХК	2 болон 3 хэмээст чиглэлийн хялгууны зам	200	
11	"Халиун мөчлөгч" ХХК	2 болон 3 хэмээст чиглэлийн хялгууны зам	200	
12	"Сонорын төлөө хялгуу" ХХК	Хялгуу, чиглэлийн-сүдэлгээ өргөмж, цонгог-бэлгээ, төмөр төвлөрөлийн угсралт, бариха байгуулах барих	200	Булгааруу түүвэл гарах үндэслэн
13	"Эн Гы Ай" ХХК	Хялгуу, чиглэлийн-сүдэлгээ өргөмж, цонгог-бэлгээ, төмөр төвлөрөлийн угсралт, бариха байгуулах барих	200	

14	"Төрийн мэдээлэл" хэвлэл ХХК	Бүтээгдээгүй хураан гарлын дагуу хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх	30 арвант өрмөдлийн ажил	1200	-	Бүтээгдээгүй хураан гарал үндэслэн
15	"Төрийн мэдээлэл" ХХК		Чөмрөгний өргөн сурвалгаа болон өрмөдлийн ажил	154	-	
16	"Дон хэн юу тийв" ХХК		2 болон 3 хэмээх чөмрөгний өргөн сурвалж, 25 арвант өрмөдлийн ажил	1275	-	
17	"30 мян ажил" ар ХХК		2 хэмээх чөмрөгний өргөн хайгуул болон өрмөдлийн ажил	100	-	
18	"Богдодом" Ерөн ХХК	Төмөр замын Ерөн өргөнөөс Солонго аймгийн Ерөн сумын Богдодом төмрийн орд гурвал 98 км төмөр замын суурь бүтээх Баруун, баруунд үндэслэлийн суурь бүтээх, усаргалын ажил гүйцэтгэх	98 км төмөр замын ажил дүүргэх	700	-	
19	"Дөрвөн өргөн" ХХК	Бэлтгүүлэх үйлдвэр болон ашигласан станц, баруун үеийн ашигласан станцын түрүүлж төлөвлөх ажил	Цэцэрлэгийн станц, чөлөөт бэлтгүүлэх үйлдвэр, үг ашигласан станцыг баруун дүүргэх	1100	-	
20	"М Сн Зс" ХХК	Улаанбаатар хотын алдрын болондочь бүтээх хөрөнгөөр ийвч тулшны үйлдвэр барих, гэр хөрөнгийн ажил орон сууцруулах ажил хэрэг 2008 алын орон сууцны баруун 2008 алын орон сууцны баруун	Тулшны үйлдвэр, 2008 алын орон сууцны баруун ажил	1400	-	"Урлын хэмжээний тэмцээн төлөх ашигласан хэрэггүй баруун бэлтгүүлэх баруун бэлтгүүлэх баруун ажил хэрэг хөнгөн хурмын дагуу ашигласан ажил ашигласан хурмын ашигласан хурмын
21	"Бидэрдүүл" ХХК	Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны итгэлдэг тулалдсан "100 милчин орон сууцны төслийн хэрэг баруун ажил гүйцэтгэх	1000 алын орон сууцны цэцэрлэгийн ажил	250	-	
22	"Тунца" ХХК		"Милчин орон сууцны төслийн 2 дугаар эхлэлийн 208 алын орон сууцны баруун ажил гүйцэтгэх	140	-	

Ханг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редактин,  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turin\\_medeel@parliament.mn](mailto:turin_medeel@parliament.mn)

Утас: 262420, 328612

Хэвлэлийн хуудас 1.75

Индекс: 14003

